



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/86

Арвайхээр сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус аймгийн Баянгол, Сант, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Өлзийт, Тарагт, Гучин-Ус сумдад оношлогдсон мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчний халдварлалтыг хязгаарлах хүрээнд бог малын шилжилт хөдөлгөөнийг зогсоож, 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл өвчний голомттой нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчний голомтын бүсийн хилийн заагийг нэгдүгээр, Гамшгаас хамгаалах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хорио цээрийн дэглэмийн үед орон нутагт ажиллах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг томилж, хүн хүчний тооцоо судалгаа гарган шаардлагатай хэсэгт байнгын ажиллагаатай хяналтын цэг ажиллуулахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Мал, амьтны гоц халдварт өвчний голомт бүхий бүс нутагт бог малыг тээвэрлэх, тууварлах шилжилт хөдөлгөөнийг хориглож, малаас гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүнийг тээвэрлэх, худалдах, хүн мал, амьтны бөөгнөрөл бий болгох арга хэмжээ зохион байгуулахгүй байх, гоц халдварт өвчний голомт бүхий сумдын мэргэжлийн анги, мэргэжлийн багийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Г.Чимэддагва), Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т тус тус үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0177

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дүгээр сарын 05 ны өдрийн 0000 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХОНИНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ГОЛОМТ  
БОЛОН СЭЖИГТЭЙ, ЭРСДЭЛТЭЙ БҮСИЙН ЗУРАГЛАЛ**

2024.02.01-ны байдлаар



7 сумын 15 голомтод 188 өрхийн өвчилсөн 5969 мал

Сэжигтэй бүсэд 4 сумын 40 өрхийн 10339 мал



Голомтын хүрээ

Эрсдэлтэй бүс

Аймгийн Засаг даргын 2024 оны 26 дугаар  
сарын 05 -ны өдрийн 26 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



**ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ҮЕД  
АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: А.Нямдаваа (Мал эмнэлгийн газрын дарга)

Гишүүд:

Б.Алтанзул(Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга)

Ц. Төмөрбат (МЭТ, МЭҮН болон дотоод хяналт, шилжилт хөдөлгөөн, баталгаажуулалт, эмийн хяналтын асуудал хариуцсан хяналтын улсын байцаагч)

Б.Ариунцэцэг(Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)

Х.Мөнхцэцэг (Лабораторийн эрхлэгч)

Л.Оюунжаргал (Зооноз, халдварт өвчин, тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн)

А.Энхтүвшин (Өвчний мэдээ тайлан, цахим бүртгэл, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Т.Оюун-Эрдэнэ (Шимэгчтэх, халдваргүй өвчин, малын эм биобэлдмэлийн хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Л.Баяр (Нян судлалын шинжээч эмч)

С.Саранцэцэг (Ийлдэс судлал, шимэгч судлалын шинжээч эмч)

Э.Улам-Ундрах (Ариун цэвэр, магадлан шинжилгээний эмч)

(Хонь, ямааны цэцэг өвчний голомт бүхий сумын Мал эмнэлгийн тасгийн дарга, тархвар зүйч нар)